

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН

2016 оны жилийн эцсийн байдлаар

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний биелэлтэд 2016 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний 2, 5, 7, 9, 12 дугаар зорилтын хүрээнд нийт 15 зорилт, арга хэмжээ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд хамаарч байна. Эдгээрээс 1 зорилт, арга хэмжээг үнэлэх боломжгүй, 4 зорилт, арга хэмжээ 100 хувьтай, 4 зорилт, арга хэмжээ 90 хувьтай, 6 зорилт, арга хэмжээ 70 хувьтай тус тус үнэлэгдсэн бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэрэгжүүлсэн зорилт, арга хэмжээний биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 84.2 хувьтай байна.

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлт /2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Бодлогын зорилт	Заалтын тоо	Хэрэгжилтийн явц /хувь/							Үнэлэх боломжгүй	Биелэлт /хувь/
			100%	90%	70%	50%	30%	10%	0%		
1	Зорилт 2. Санхүүгийн эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, үр ашгийг дээшлүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	3	1	1	1	-	-	-	-	-	86.6
2	Зорилт 5. Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.	5	1	1	2	-	-	-	-	1	82.5
3	Зорилт 7. Бодит салбарын өсөлтийг хангах эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, шинэ эх үүсвэрүүдийн барилгын ажлыг эхлүүлнэ.	6	1	2	3	-	-	-	-	-	81.6
4	Зорилт 12. Хөдөөгийн хөгжлийг дэмжиж, хүн амын амьдрах орчныг сайжруулна.	1	1	-	-	-	-	-	-	-	100.0
	Дүн	15	4	4	6	-	-	-	-	1	84.2

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэрэгжүүлсэн зорилт, арга хэмжээний биелэлтийг үзүүлбэл:

- 100 хувийн хэрэгжилттэй:
 - 2.1 Хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
 - 5.1 Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах;
 - 9.5 Уул уурхайн үйл ажиллагаанаас болж эвдрэлд орсон талбайд нөхөн сэргээлт хийлгүүлэх;
 - 12.8 Эрчим хүч, авто бензин, дизелийн түлшний үнийг Монгол Улсын хэмжээнд ижил байх эрх зүйн орчныг бүрдүүлэх.

- 90 хувийн хэрэгжилттэй:
 - 2.4 Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх;
 - 5.7 Цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох асуудлаар харилцагч талтай хэлэлцээр хийх, бодлогыг Улсын Их Хуралд танилцуулах;
 - 9.1 Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх;
 - 9.3 Ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх.

- 70 хувийн хэрэгжилттэй:
 - 2.5 Таван толгойн төслийг үргэлжлүүлэх;
 - 5.2 Зэс хайлуулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх;
 - 5.3 Нүүрсийг шингэрүүлэх, хийжүүлэх, хуурай аргаар боловсруулах үйл ажиллагааг бодлогоор дэмжих;
 - 7.5 Эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг хангах зорилгоор Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх;
 - 9.2 Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын нөөцийн агуулах барихад дэмжлэг үзүүлэх;
 - 9.4 Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын Холбооны стандартыг нутагшуулж, мөрдүүлэх.

5.8-д заасан Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд цахилгаан станц байгуулж эрчим хүч экспортлох чиглэлээр холбогдох талтай хэлэлцээ хийх зорилт, арга хэмжээний хувьд Эрчим хүчний яам толгойлон хэрэгжүүлэх ба хэлэлцээр хийх ажлын хэсгийг байгуулсан тохиолдолд манай яамны төлөөлөл оролцож ажиллахаар төлөвлөж байгаа тул үнэлгээ хийх боломжгүй байна.

ДҮГНЭЛТ:

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд 2016 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэрэгжүүлсэн зорилт, арга хэмжээний биелэлт 84.2 хувьтай дүгнэгдлээ.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний 2.5, 5.2, 5.3, 7.5, 9.2, 9.4 дэх зорилт, арга хэмжээнүүд 70 хувийн биелэлттэй байгаа тул эдгээр зорилт, арга хэмжээг эрчимжүүлж, биелэлтийн түвшинг өсгөхөд онцгой анхаарах шаардлагатай байна.

Цаашдаа өргөн цар хүрээг хамарсан, томоохон зорилт, арга хэмжээг тодорхойлон боловсруулахдаа шалгуур үзүүлэлт болон хүрэх түвшинг уялдуулан, бодит тооцоо судалгааг үндэслэх нь чухал ач холбогдолтой бөгөөд доорх санал, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ:

1. Хэрэгжилт хангалттай бус байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлж, биелэлтийн түвшинг өсгөхөд анхаарч ажиллах;
2. Биелэлтийг гаргахдаа үг, үсгийн болон утга найруулгын алдаагүй тайлагнах, холбогдох тушаал шийдвэрийн огноо, дугаарыг тодорхой дурдах;
3. Зураг дүрс, график, тоон үзүүлэлтээр илэрхийлж болох зорилт, арга хэмжээний биелэлтийг өсөлт бууралт, өөрчлөлт, статистик мэдээллийн нэгтгэлийн хамт биелэлтэд хавсаргах;
4. 2017 оны Үндсэн чиглэлд шалгуур үзүүлэлт болон хүрэх түвшингийн хувьд биелэх боломжтой зорилт, арга хэмжээг тооцоо судалгааны үндэслэлтэйгээр тодорхойлох.

-----oOo-----

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР